

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо :2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Гүнтийн давааны орчимд Цагдаа, Мэргэжлийн хяналт, Онцгой байдлын хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагуудын байнгын пост барих барилгын ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЧДХААА А19/01**

**Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Гүнтийн давааны орчимд Цагдаа, Мэргэжлийн хяналт, Онцгой байдлын хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагуудын байнгын пост барих барилгын ажил”**-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) албан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно. Төлбөрийг Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны Төрийн сан банкны 100200751009 тоот дансанд тушаана.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн дундаж нь 110 000 000 /нэг зуун арван сая/ төгрөгөөс багагүй байна.**
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **50 000 000 /тавин сая/ төгрөгөөс багагүй байна.**
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2017, 2018/**
- Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн аль нэгэнд ядаж нэг удаа 110 000 000 /нэг зуун арван сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй барилга угсралтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.**
- Шаардлагатай тусгай зөвшөөрөл:
- **2.1.1.** Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт
- **2.1.3.** Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн, барилгын ажил (1-9 давхар хүртэл) Ган бүтээцэн барилгын ажил (фермийн алгасал нь 18 м, баганын өндөр нь 6 м хүртэл)
- **2.2.1.** Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- **2.2.2.** Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний

угсралт

Эсхүл, Барилга хот байгуулалтын яамнаас олгож байгаа шинэ журмын:

- БА-3.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил.
- БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт.
- БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт.
- БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна шугам сүлжээний угсралт.
- БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна шугам сүлжээний угсралт.

Тендерийн хамт **3 000 000 /гурван сая/** төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 30** минутанд нээнэ.

Гадаадын этгээд: Оролцох эрхгүй.  
Дотоодын давуу эрх: Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо, Ж.Самбуугийн гудамж-16,  
Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, 511 тоот өрөө  
Худалдан авах ажиллагааны алба, Утас : 70110769**